

“БАЯНТЭЭГ” ХК

“БАЯНТЭЭГ” ХК

2017 оны эхний хагас жилийн үйл ажилгааны товч тайлан

Компанийн нэр: ”Баянтээг” ХК

Хаяг: Өвөрхангай аймаг, Нарийнтээл сум, II-р баг, Баянтээг

Утас: 98320100,

Улсын бүртгэлийн дугаар: 1010001008

Регистрын дугаар: 2014491

Үйл ажиллагааны чиглэл: Чулуун нүүрс олборлолт

Хувьцаа эзэмшигчдийн тоо: 244 хувьцаа эзэмшигчид 252608 ширхэг хувьцааг эзэмшиж байна /2017 оны 04 сарын 18-ны өдрийн тархалтын судалгаа/

Ашиглалтын системийн сонголт:

Ашиглалтын систем

Баянтээгийн нүүрсний ордыг ил уурхайн тээвэртэй ашиглалтын системээр тасралтгүй ажиллах ба 2017 оны уулын ажил нь хөрс хуулалт, нүүрс олборлолт, нөхөн сэргээлт, ус таталт гэсэн дөрвөн хэсгээс бүрдэнэ. Уулын бэлтгэл ажлын хүрээнд 2013 онд шинээр бий болгосон уурхайн үндсэн гол амыг сэргээн хөрс хуулалт, нүүрс олборлолтыг явуулна. Энэ ажлыг уурхайн үндсэн техник болох ЭКГ-5А экскаватор, HYUNDAI 2900, HYUNDAI 520LC-9S экскаваторууд, TEREХ 3305E 2ш, NORTH BENZ 4ш, HOWO-60 2ш автосамосвалууд, СВБ-2М өрмийн машин 1ш, JD-1400E өрмийн машин 1ш, D65E бульдозер 1ш, LG-930 дугуйт ачигч 1ш, SD-300 дугуйт ачигч 1ш зэрэг техникийн хослолоор хийж гүйцэтгэнэ. Хөрсийг гадаад овоолгод, нүүрсийг хэрэглэгчдийн тээврийн хэрэгсэлд шууд ачуулна.

Уулын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл :

Баянтээгийн нүүрсний уурхайн үйлдвэрлэлийн хүчин чадлын өсөлт нь аймгуудын эдийн засгийн тогтвортой хөгжилтэй холбоотой бөгөөд уурхайн хүчин чадлыг захиалагч буюу өмнөх онуудын нүүрс олборлолтыг үндэслэн 2017 онд уурхай 350,0 мян.м3 хөрс хуулан, 120,0 мян.тн нүүрс олборлож, 2.9 м3/тн хөрс хуулалтын дундаж коэффициенттойгоор ажиллана.

Эхний хагас жилийн байдлаар 315,2мян/м3 хөрс хуулж, 44,6 мян/тн нүүрс олборлон борлуулж, борлуулалтын орлого 891790,5 мян/төг болж нийт ажилчдад 272579,3 мян/төгрөгний цалин тавьж, бичиг хэргийн зардал 451,9 мян/төг, албан

“БАЯНТЭЭГ” ХК

томилолтын зардал 6766,0 мян/төг, хэвлэл захиалгын зардал 1631,3 мян/төг, ТУЗ-ын зардал 2960,6 мян/төг, ХАБЭА-н зардал 5988,4 мян/төг тус тус зардал гарсан байна

2017 оны эхний хагас жилд төлсөн татвар, шимтгэлүүд:

1. Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн 60,975.9 мян/төг
2. Татварын байгууллагад төлсөн 258,706.1 мян/төг
3. Даатгалд төлсөн 774,7 мян/төг төлсөн бөгөөд үүнээс:
 - а. ЭМ, НД шимтгэл – 26985350
 - б. Агаарын бохирдолын төлбөр - 27283600
 - в. АМНАТ - 22241175
 - г. НӨАТ – 68435643 төгрөг төлсөн байна.

“Баянтээг” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2017 оны 04 сарын 24-ны өдөр хуралдаж дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2016 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайлан батлах
2. Компанийн аудитын хорооны тайлан дүгнэлт батлах
3. Компанийн ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын 2017 оны цалин урамшуулал болон зардлын төсөвийг батлах
4. Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу хөндлөнгийн байгууллагаар аудит хийлгэх тухай Компанийн дүрэмд нэмж оруулах тухай
5. Компанийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэх

Уг хуралд хувьцаа эзэмшигчдийн 93,54% буюу 236,277 ширхэг хувьцаа эзэмшигчдийн ирцтэй оролцож хэлэлцэж буй асуудалтай холбогдож гаргасан хурлын шийдвэрийг 100 хувийн саналаар баталсан

ТУЗ-ын ердийн гишүүдээр:

1. О.Батжаргал
2. Д.Нэмэхбаяр
3. Ю.Батсайхан
4. М.Нинжбадгар

“БАЯНТЭЭГ” ХК

5. Д.Энхбат

6. Д.Миеэгомбо

7. Г.Баясгалан нар

Хараат бус гишүүдээр

1. З.Дашзэвгэ

2. Г.Батсүх

3. Р.Өлзийжаргал

4. Л.Пүрэв нар тус тус сонгогдон 2017 онд ТУЗ нь 11 гишүүнтэй ажиллаж байна.